



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A179

Бор-Өндөр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
өвлүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан иргэн (Энхбаатар овогтой Золбаяр) -д газар эзэмших эрхийн гэрчилгээг нэгдүгээр хавсралтад зааснаар өвлүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан иргэнтэй хуулийн дагуу анхдагч гэрээний хугацааг дуустал газрыг үргэлжлүүлэн эзэмшүүлж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа) -д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг авсан иргэн (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Бор-Өндөр сумын Засаг даргын 2023 оны A/70 захирамжийн иргэн (Ж.Энхбаатар) -д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2028 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн А/179-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчийн мэдээлэл

Д/д	Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /г/ж/	Газрын байршил хаяг	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Өвлүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр	Эрх шилжүүлэх үндэслэл
1	Боржгон Энхбаатар Золбаяр	СЦ94031713	711	13	4-р баг Уурхайчин, Жаргалант-10 гудамж, 1018 тоот	2322003719	Гэр бүлийн хэрэгцээ	Цэцэгэр Жигмэдсүрэн Энхбаатар E369022618	Өвлөх эрхийн гэрчилгээ 2026.03.30/0008



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Бор-Өндөр сум

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/80

Орон нутгийн хөгжлийн сангаас
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх хэсэг, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.4 дахь хэсэг, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 16 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын “Малчдад төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд шаардлагатай цахилгаан үүсгүүртэй цамхагт гэрэлтүүлэг (Генератор)” худалдан авахаар гэрээ байгуулсан “Юнитра” ХХК-д 100%-ийн санхүүжилт болох 35,440,000 (гучин таван сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг олгосугай.

2. Тус ажлын санхүүжилт болох 35,440,000 (гучин таван сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ОТГОНЦЭЦЭГ



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Бор-Өндөр сум

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/81

"Хөл бөмбөгийн талбай"-н ажлыг хүлээж авах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дэх зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн "Хөл бөмбөгийн талбай"-н ажлын гэрээг дүгнэж, хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

З.Ууганжаргал

Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

У.Дөлгөөн-Учрал

Бор-Өндөр 1 дүгээр багийн Зохион байгуулагч

Гишүүд:

И.Энхтуяа

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Ц.Ганхүү

Ерөнхий боловсролын Бор-Өндөр сургуулийн захирал

Д.Цэнд-Аюуш

ЗДТГ-ын нярав

Э.Эрдэнэбат

Иргэн


М. Мөнхцэцэг

Иргэн

2. "Хөл бөмбөгийн талбай"-н ажлыг зохих хууль журмын дагуу хүлээж авахыг ажлын хэсгийн ахлагч (З.Ууганжаргал)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/82

Бор-Өндөр сум

"Жишиг хашаа" аяныг өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бумбат 3 дугаар баг, Уурхайчин 4 дүгээр багийн айл өрхийн дунд "Жишиг хашаа" аяныг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 09 сарын 30-ны өдрийн хооронд өрнүүлсүгэй.

2. Гэр хорооллын айл өрхийн хашааны өнгө үзэмжийг сайжруулах, эвдрэл гэмтлийг засварлан шинэчлүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ч.Саруулмөнх Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Мөнгөнтуяа Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Гишүүд:

Г.Мягмарсайхан Бумбат 3 дугаар багийн Зохион байгуулагч

Д.Халиунаа 4 дүгээр багийн Зохион байгуулагч

С.Батсайхан Аравтын ахлагч


3. Бумбат 3 дугаар баг, Уурхайчин 4 дүгээр багийн айл өрхийн дунд зарлах "Жишиг хашаа" аяны удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. "Жишиг хашаа" аянд идэвх санаачилгатай оролцож, хашааны өнгө үзэмжийг сайжруулж, эвдрэл гэмтлийг засварлан шинэчилж, хамтран ажиллахыг Бумбат 3 дугаар баг, Уурхайчин 4 дүгээр багийн нийт иргэдэд үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДОТГОНЦЭЦЭГ



БАТЛАВ:
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГА *О.О.Д.* ОТГОНЦЭЦЭГ
2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

УДИРДАМЖ

БОР-ӨНДӨР СУМЫН БУМБАТ 3 ДУГААР БАГ, УУРХАЙЧИН 4 ДҮГЭЭР БАГИЙН
"ХАШАА ХӨТӨЛБӨР"-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

2026.04.01

Нэг. Ерөнхий үндэслэл

Бор-Өндөр сум

Бор-Өндөр сумын Бумбат 3 дугаар баг, Уурхайчин 4 дүгээр багийн айл өрхүүдийн хашаа, стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх, сайжруулах замаар орчны аюулгүй байдал, тохижилт сумын өнгө үзэмж, иргэдийн амьдрах орчны чанарыг дээшлүүлэх зорилгоор энэхүү "Хашаа хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

Хоёр. Зорилго

Бор-Өндөр сумын Бумбат 3 дугаар баг, Уурхайчин 4 дүгээр багийн айл өрхийн хашааг жигд, аюулгүй, стандартын шаардлагад нийцсэн болгох, хот байгуулалт орчны тохижилтыг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Зорилт

3.1 Эвдэрч муудсан, стандартын шаардлага хангахгүй хашааг шинэчлэх, засварлах, гудамж талбайг цэгцлэх

3.2 Хашааны өндөр, материал, өнгө үзэмжийг жигдлэх талаар зөвлөмж өгөх

3.3 Иргэдийн оролцоонд тулгуурласан хамтын ажиллагааг бий болгох

3.4 Аюулгүй байдал, галын эрсдэлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх

Дөрөв. Хамрах хүрээ

5.1 Хашаа, хашаалгын судалгаа, тооллого хийх

5.2 Стандарт, зөвлөмж боловсруулах, иргэдэд сурталчлах

5.3 Шаардлагатай айл өрхүүдийг үе шаттайгаар хамруулах

5.4 Иргэдийн санаачилгыг дэмжих

Долоо. Гүйцэтгэлийн үе шат

7.1 Бэлтгэл үе шат /судалгаа, тооллого, төлөвлөлт/

7.2 Хэрэгжилтийн үе шат /материал түгээл, угсралт, засвар/

7.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ /явцын тайлан, дүн шинжилгээ/

Найм. Хяналт үнэлгээ

8.1 Багийн Засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.

8.2 Сар тутам явцын тайлан гаргаж, сумын Засаг даргад танилцуулна.

8.3 Стандарт хангаагүй тохиолдолд зөвлөмж өгч, дахин сайжруулах арга хэмжээ авна.

Ес. Урамшуулал, хариуцлага

9.1 Шилдэг жишиг хашаа, идэвхтэй оролцсон айл өрхийг урамшуулна.